

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр, 19 дүгээр зүйлд “1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан. Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хүний үндсэн эрхийг баталгаажуулж өгсөн байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”, 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж нарийвчлан тодорхойлжээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хэн ч бусдын эрх, нэр төрд халдаж болохгүй нь тодорхой. НЭР ТӨР гэдэгт тухайн хүний албан тушаал, хөрөнгө мөнгө, авьяас чадвар, гаргасан ажлын амжилт, олны хүндэтгэлийг хүлээсэн эсэх бус хүн болж төрснийхөө хувьд бусдаар хүн гэж хүлээн зөвшөөрүүлж хүндлүүлэхийг ойлгодог. Харин НЭР ХҮНД, АЛДАР ХҮНД гэх хууль зүйн ойлголт нь хүн хөдөлмөр зүтгэл, авьяас билиг, ур чадвар, ёс суртахууны эрхэм чанараараа бусдаас буюу нийгмээс олж авч, унаж ба босож байдаг үнэлгээг илэрхийлсэн хууль зүйн зааг ялгаатай ойлголтууд юм. Тэр ч утгаараа НЭР ТӨР, НЭР ХҮНД, АЛДАР ХҮНД нь тус бүртээ ялгамжтай хууль зүйн хамгаалалт, ялгамжтай эрхийн зохицуулалтыг шаарддаг. Хүн бүр өөрөөс нь салгаж, хэмжиж үл болох эрхэмсэг оршихуйтай бөгөөд хүнийг хүн болохынх нь хувьд хүлээн зөвшөөрч, хүнд заяагдмал байх эрхийг хуулиар хамгаалах нь төрийн үүрэг. Ингэж хамгаалахдаа хуульд үүнийг хэрхэн зохицуулах талаар эрдэмтэн судлаач, холбогдох байгууллага, албан тушаалтнуудын дунд хэлэлцүүлэг өрнөсний үр дүнд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, 2015 оны Эрүүгийн хуульд “худал мэдээлэл тараах” гэсэн

13.14 дүгээр зүйл нэмсэн. Ингэснээр Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн гүтгэх зөрчлийг хүчингүй болгож, хүний нэр төр, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр төрд халдаж, үндэслэл нотолгоогүйгээр илт худал мэдээлэл олон нийтэд тараасан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хүний нэр төрийг Эрүүгийн хуулиар хамгаалахаар болсон.

Засгийн газраас тухайн үед УИХ-д өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд оруулсан тухайн нэмэлтийн төсөлд хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүний нэр төрөө хамгаалуулах эрхийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, аль нэг эрх нөгөөгөөсөө болж зөрчигдөхөөс хамгаалсан тайлбар байсныг хуулийн төслийн талаар холбогдох байгууллагын саналыг авах үед Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн саналаар хасах санал гаргаж хассан нь харамсалтай.

Уг хасагдсан тайлбарт гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллагыг тооцохгүй байх, үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийн хувь хүнийх нь нэр төрд халдсан бус, зөвхөн эрхэлж буй албан тушаалынхаа хүрээнд олж авсан эрх мэдэлтэй нь холбогдуулж хардаж сэрдсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар заасан байсан юм.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, хүний эрхийн зөрчлийг илрүүлж, олон нийтэд мэдээлэхэд хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчдийн үүрэг оролцоо асар их юм. Иргэдийн мэдэх, мэдээлэлтэй байх эрхийг хэрэгжүүлж, тухайн нийгмийн харилцаан дахь зөрчил, доголдолтой асуудлыг илчлэн нээлттэй болгож, асуудал дэвшүүлэн олон түмэнд мэдээлдгээрээ сэтгүүлчид хүний эрхийн хамгаалагчид болдог.

Улс төрд нөлөө бүхий этгээд нь иргэд, олон түмний сонголтын үндсэн дээр төрийн өндөр албан тушаал хашиж байгаагийнхаа хувьд ард иргэддээ нээлттэй, ойлгомжтой, элдэв хууль бус хардалт сэрдэлтэд өртөхөөргүйгээр албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үүрэгтэй билээ. Иймд албаны бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаатай нь холбогдуулан иргэд, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс гаргасан хардаж гүтгэсэн гэж Эрүүгийн журмаар гомдол гаргах эрхгүй гэж үзэж энэхүү хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлов. Харин хүн болохынхоо хувьд бүх хүний хувьд адил тэгш заяагдсан нэр төрд нь халдлаа гэж Эрүүгийн журмаар гомдол гаргах эрх нь Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заасанчлан эдлэгдэнэ. Тухайлбал, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж хахууль авсан гэх мэдээллийн талаар Эрүүгийн журмаар гомдол гаргахгүй (Иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах эрхийг хөндөхгүй), харин хувь хүнийх нь хувьд хүнийг дайрсан, алсан, хүчиндсэн гэх гэмт хэрэгт холбогдуулж гүтгэсэн асуудлаар Эрүүгийн журмаар гомдол гаргах эрхтэй байна гэсэн үг юм.

Иймд хүний үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хөндөхгүйгээр, хүний нэр төр, эрхэмсэг оршихуйг хамгаалж, эдгээр эрхүүдийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлах нь зүйтэй гэж хууль тогтоогчид үзлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нийт 2 зүйлтэй. Уг төслийн 1 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд хоёр хэсэг бүхий тайлбар нэмэх талаар зохицуулна. Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй тухай тайлбар оруулна. Ингэснээр төрийн байгууллага, улс төрд нөлөө бүхий этгээд Эрүүгийн хуулийн заалтыг өөрт ашигтайгаар хэрэглэж, төрийн албаны үйл ажиллагаатай нь холбогдуулан шүүмжилсэн, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдсон талаар хардаж мэдээлэл түгээсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийг Эрүүгийн хэрэг үүсгүүлж, улмаар мэдээллийн эх сурвалжийг хэлэхийг шахах, дарамтлах, улмаар иргэдийн мэдэх эрхийн амыг үдэх боломж олгосон эрх зүйн үндэс арилна.

Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг албаны бүрэн эрхээ хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулж хардсан, сэрдсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй талаар тайлбар оруулах юм. Ингэснээр хүний үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хөндөхгүйгээр, улс төрд нөлөө бүхий этгээдийн хүний нэр төр, эрхэмсэг оршихуйг хамгаалж, сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх эрх боогдохгүй байх эрх зүйн үндэс бий болно. Өөрөөр хэлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон нэр төрөө хамгаалуулах эрхийг зохицтой түвшинд тэнцвэртэй хамгаалах боломж бүрдэх юм.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн гарчгийн “худал мэдээлэл тараах” гэснийг “гүтгэх” болгон өөрчилж, илт худал мэдээлэл олон нийтэд тараасан үйлдлийг бус илт худал гүжирдсэн үйлдлийг энэ гэмт хэрэгт тооцохоор болно. Учир нь хүний нэр төр, алдар хүндэд санаатай халдаагүй хүн Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцогдохоор байна.

Иймд уг гэмт хэргийн объектив шинжийг тодорхой болгож, санаатайгаар гүжирдлэг явуулан хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан этгээдэд л хариуцлага хүлээлгэх шаардлагатай. Ийнхүү одоо хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтаар шүүгчийг эрүүгийн хэргийг шийдэхээс өмнө худал мэдээлэл түгээгч нь аль хэдийнэ хэрэгтний ширээнд сууж, хэвлэлийн эрх чөлөө хязгаарлагддаг байдлыг өөрчлөхийн тулд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлах нь зүйтэй гэж хууль санаачлагчид үзлээ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧИД